



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/70

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аюулгүй байдал, хамгаалалтын албаны тусгай зориулалтын нохойн хоол /4000кг/” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга: М.Гүен

Аюулгүй байдал, хамгаалалтын албаны дэд  
дарга

Нарийн бичгийн  
дарга: Б.Мөнхбаатар

Худалдан авах ажиллагааны тасгийн  
мэргэжилтэн

Гишүүд:

Н.Төмөрбаатар

Аюулгүй байдал, хамгаалалтын албаны Үзлэг  
шалгалт хамгаалалтын хэсгийн менежер

О.Тэмүгэ

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

Ц.Дарханбат

“ТАКТИЖЕНТ” Төрийн бус байгууллагын тэргүүн

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (М.Гүен)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Мөнхбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ

